



БАТЛАВ. МОНГОЛЫН ДААМЫН ХОЛБООНЫ

ЕРӨНХИЙЛӨГЧ

О.МЭНДБАЯР

2016 ОНЫ УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ 64 БУУДАЛТ, ТУРК ДААМЫН ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

Нэг. Нийтлэг зүйл

1. Тэмцээний зорилго нь 64 буудалт болон Турк даамын спортыг сурталчилж хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, 2016 оны Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчдыг сонгон шалгаруулахад оршино.
2. Тэмцээн эрэгтэй, эмэгтэй ангиллаар,
 - 2.1. 64 буудалт даамын үндсэн (Бразил даамын дүрмээр, ө.х. 100 буудалттай ижил)
 - 2.2. 64 буудалт даамын блиц (Бразил даамын дүрмээр, ө.х. 100 буудалттай ижил)
 - 2.3. Турк даам зэрэг 3 төрлөөр зохиогдоно.
 - 2.4. Дээрх бүх тэмцээн нээлттэй зохиогдоно. Өөрөөр хэлбэл бүх насныхан оролцож болно.
3. Тэмцээн Монголын даамын холбооны тэмцээний дүрмийн дагуу явагдана.

Хоёр. Тэмцээний журам

1. Тэмцээн 2016 оны 05-р сарын 6, 7-нд Баянзүрх дүүргийн Бадмаараг төвд явагдана.
2. Тэмцээнийг Монголын даамын холбоо зохион байгуулж, шүүгчдийн бүрэлдэхүүнийг томилно.
3. Тамирчдын бүртгэлийг 2016 оны 4 дүгээр сарын 30-ныг дуустал хүлээн авна.
4. Тэмцээний хураамжийн хэмжээ:
 - 4.1. 64 буудалт, үндсэн – 10,000 төг
 - 4.2. 64 буудалт, блиц – 10,000 төг
 - 4.3. Турк даам – 5,000 төг
5. ТЭМЦЭЭНИЙ ХУРААМЖ-ийг Монголын даамын холбоо, 1102102442, Голомт банк гэсэн дансанд тушаахад бүртгэл автоматаар хийгдэнэ. *Гүйлгээний утга дээр овог нэр, оролцох төрөл, хүйс зэргийг бичих шаардлагатай.*
6. Тэмцээний оролцох тамирчдын тоо гүйцтэл түүрүүлж бүртгүүлсэн тамирчныг бүртгэх байдлаар бүртгэл явагдаж, тоонд хүрмэгц бүртгэл хаагдана.
7. Тэмцээний нээлт 2016 оны 5 дугаар сарын 6-нд 14:00 цагаас Бадмаараг төвийн байранд болно.

8. Монголын даамын холбооны дүрмийн дагуу гишүүний татвараа төлсөн тохиолдолд тэмцээнд оролцох эрхтэйг анхаарна уу.

9. Цагийн хяналт талдаа 15 мин-аас багагүй байна. Блиц 3мин + 1сек

10. Бүртгэлийг хүлээн авсны дараа тэмцээнд оролцогчдын тоог харгалзан швейцарь системээр 7-9 өрөг тоглож дүнг гаргана.

11. Тоглогчдыг хожлын тоогоор цуваагаар байр эзлүүлэн, хожлын тоо тэнцсэн үед дараахь шалгуурыг баримтална. Үүнд:

- Солкоф коэффициент
- Медиан Солкофф коэффициент

Гурав. Шагнал, урамшуулал

1. Ангилал тус бүрт эхний 3 байрт шалгарсан тамирчид медаль, диплом, мөнгөн шагналтай.
2. Ангилал бүрт эхний 5 байрт шалгарсан тамирчид тухайн ангиллын 2016 оны Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрхтэй болно.

МОНГОЛЫН ДААМЫН ХОЛБОО

Холбоо барих утас: 9916-4205

Email: daam@mondaam.mn

Web: www.mondaam.mn